



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭЭДЭЭ

№107 /321/

2022.06.09

Цаг үе, үйл явдал

“КАНСАТ – 2022” ҮНДЭСНИЙ V ТЭМЦЭЭНД ҮБХИС-ИЙН БАГ ГУТГААР БАЙР ЭЗЭЛЛЭЭ



Монгол Улсад сансрын технологийг хөгжүүлэх, салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, хүүхэд, залуус, инженер судлаачид болон олон нийтэд шинжлэх ухааныг зөв таниулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд чухал ач холбогдолтой “КАНСАТ – 2022” үндэсний V тэмцээн амжилттай болж өндөрлөлөө.

Тус тэмцээнд МУИС, ШУТИС, ХААИС, ҮБХИС, Шинэ Монгол, Монгол Коосен зэрэг найман их дээд сургуулийн 15 багийн 90 гаруй оюутан, залуус оролцож, өөрсдийн бүтээсэн

сансрын бага оврын хиймэл дагуулыг хөөргөж, өрсөлдлөө.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам, MOSTA - Монголын Сансрын Технологийн Холбоо, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, Нийслэлийн Бизнес инноваци хөгжлийн газар, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Монгол Улсын Их Сургууль хамтран зохион байгуулсан тус тэмцээн “Кансат”, “Буцагч” гэсэн хоёр төрлөөр явагдсан юм.

Тэргүүн байрыг ШУТИС-

ийн Мэдээлэл холбоо, технологийн сургуулийн HIGH TECH, дэд байрыг “Шинэ Монгол” технологийн коллежийн NEW SPACE, гутгаар байрыг ҮБХИС-ийн АРАБТ баг эзэллээ.

Авьяас чадвар, мэдлэг, оюунаа дайчлан амжилттай оролцсон АРАБТ баг тэмцээний дээрх төрлүүдэд тус тус гутгаар байрыг эзэлсэн юм.

Шагналыг Монгол Улсын баатар, сансрын нисгэгч Ж.Гүррагчаа, Шүүгчдийн зөвлөлийн гишүүн ШУА-ийн Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Сувданчимэг, ШУА-ийн Одон

орон, геофизикийн хүрээлэнгийн захирал, академич, доктор С.Дэмбэрэл, МУИС-ийн багш, доктор Д.Эрдэнэбаатар, Монголын Цахилгаан Холбоо ХК-ий ахлах мэргэжилтэн Ц.Оюунцаг нар гардуулан өглөө.

Тэмцээнийг зохион байгуулагч, шүүгчдийн зүгээс энэхүү тэмцээнээс олж авсан мэдлэг, туршлагаа цаашид Монгол Улсдаа сансрын технологийг хөгжүүлэхэд зориулаарай гэв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 14	☁️ 0


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	☁️ 25

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,123.00	3,127.0
EUR 🇪🇺	3,355.0	3,365.0
CNY 🇨🇳	469.00	471.00
RUB 🇷🇺	46.00	46.50
JPY 🇯🇵	24.00	24.30
KRW 🇰🇷	2.51	2.53

ЗУРХАЙ



2022.06.09 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 10

ЗУНЫ ИЛҮҮ ТЭРГҮҮН САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Эрч хүч ихэснэ

Наран ургах, шингэх:

04.54-20.49

Барилдлага:

Хотол чуулган

Шүтэн барилдлага:

Хуран үйлдэхүй

Суудал: Уул

Энэ өдөр тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнес эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогдод баруун хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрч хүч ихэснэ.

ХАРШИЛТАЙ, АСТМАТАЙ Ч ЧӨЛӨӨТЭЙ АМЬСГАЛЪЯ



Жил бүрийн 6 дугаар сарын 5-11 нь харшлын эсрэг дэлхийн өдрүүд аж. Энэхүү харшлын эсрэг дэрхийн өдөрт Цэргийн төв эмнэлэг нэгдэж тус эмнэлгийн арьс харшлын тасгаас “Харшилтай, астматай ч чөлөөтэй амьсгалъя” өдөрлөгийг өнөөдөр зохион байгууллаа.

Өдөрлөгийн хүрээнд Цэргийн төв эмнэлгийн болон Улаанбаатар цэргийн хүрээний Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудын эмч нарт АШУУИС-ийн Био-Анагаахын сургуулийн багш анагаах ухааны доктор Л.Наранцаг, Уушги-харшил судлалын тэнхимийн багш анагаах ухааны магистр Ц.Найдансүрэн нар Ургамлын тоосны харшил, Монголд хийгдсэн судалгаанууд, астма, уушгины архаг бөглөрөлт өвчлөл зэрэг сэдэвт сургалтыг зохион байгуулав. Үргэлжлээд Цэргийн төв эмнэлгийн Арьс харшлын эмч хошууч Э.Нарантунгалаг поликлиникээр үйлчлүүлж байгаа иргэдэд харшлын ринит, астма өвчний талаар яриа таниулга хийхийн зэрэгцээ зарим үйлчлүүлэгчдэд харшлын сорил үнэгүй тавьж зөвлөгөө өглөө.

Мөн Цэргийн төв эмнэлэгтэй хамтран ажилладаг денк фарм, монос командуудын бүтээгдэхүүн танилцуулахын зэрэгцээ зарим үйлчлүүлэгчдэд остеодегенетотер буюу ясны сийрэгжилт үзэх, био энергийн аппаратаар оношилгоо хийж зөвлөгөө өгч ажиллаа.

Ташрамд харшил нь сүүлийн

үед нийгмийн хөгжилтэй холбоотой улам ихсэж байгаа эмгэг бөгөөд ямар орчинд амьдарч байгаа, хүрээлэн буй орчинд хортой бодис байгаа эсэхээс хамаарч зарим төрлийн өвчин үүсэж болох ба ийм өвчний тоонд харшил орж буй юм.

Түүнчлэн харшил нь хүний дархлааны системтэй холбоотойн дээр хүний арьс болоод зарим төрлийн бодист хэт мэдрэмтгий болох үйл явц юм.

Мөн бронхит багтраа, тоосонцрын харшил, чонын хөрвөс, эмийн харшил, хүнсний харшил, шавжны харшил гэх мэт олон янзын зонхилон тохиолддог харшлын өвчнүүд байдаг. Энэ өвчний үеэр арьсан дээр юм гарах, загатнах, нүд улайх, нус нулимс гарах, үе үе амьсгал боогдох буюу амьсгал давчдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Тоосонцрын харшил нь дээр нэрлэсэн өвчнүүдийн дотроос хамгийн элбэг тохиолддог. Гол төлөв ургамлын тоосонцроос ялангуяа хог ургамал, шарилж, лууль зэрэг ургамлын тоосноос гадна гэрийн, үйлдвэрийн, номын тоосноос үүсдэг.

Хүний амьдарч буй орчин бохир байснаас эсвэл арьсанд хэт цочрол өгдөг тос, металл зүүлт, зарим хүнсний бүтээгдэхүүнээс арьсны харшил үүсэж болно. Зарим харшлын өвчин нь халдварлаж, удамшиж ч болдог аж.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 538,142,018

Эдгэрсэн

Нийт: 511,433,605

Нас барсан

Нийт: 6,326,583

Цахим шууданд

ЭНХИЙГ САХИУЛАГЧ НАР САЙН ҮЙЛСИЙН АЯНД НЭГДЛЭЭ



аймаг дахь Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудаас энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт байгаа эх, хүүхэд болон цэргийн албаа хааж байгаа зарим байлдагч нарын ар гэрт тусламж үзүүлээ.

Мөн даяндэлхийн энх цагийн баатрууд болсон энхийг сахиулагч нараа аймгийн удирдлагууд хүлээн авч хүндэтгэл үзүүлэхийн зэрэгцээ аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр энгэрийг нь мялаалаа.

Ахмад Г.МӨНХБАЯР

Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб
Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд

оролцож эхэлсний түүхт 20 жилийн ой, олон улсын энхийг сахиулагчдын өдрийг тохиолдуулан Говь-Алтай

"ДӨЛ-2022" ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭН ШИЛДГҮҮД ШАЛГАРАВ



Увс аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч хүмүүжил олгох, эх орон эх хэл, түүх, соёл, уламжлал, ёс заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх үүднээс аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг 2 үе шаттайгаар явуулж шилдгүүдээ шалгаруулав. Тус тэмцээнд Улаангом сумын Ерөнхий боловсролын сургуулийн 6 тасаг, Зүүнговь,

Баруунтуруун, Ховд, Бөхмөрөн сумуудын Ерөнхий боловсролын 10 тасаг, 110 сурагчид шилжин явах цом 36 багц медалийн төлөө өрсөлдөв. Хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн тэмцээний нэгдүгээр байранд Увсын тэргүүний цогцолбор нэгдүгээр сургуулийн сурагч Ц.Мөнгөнбаяр захирагчтай тасаг, хоёрдугаар байранд ахлах гуравдугаар сургуулийн сурагч Н.Тэмүүжин захирагчтай тасаг, гуравдугаар байранд ахлах зургаадугаар сургуулийн сурагч

Н.Амарбаясгалан захирагчтай тасаг тус тус шалгарсан юм. Тэмцээний эхний 3 байранд, шалгарсан багуудын 33 сурагч, удирдагч багшийг оролцуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэр бум" мод үндэсний хөдөлгөөнд нэгдэн Улаангом хотын төв гудамжинд мод тарьж, "Эх орны үзэсгэлэнт байгаль-Дархан хил аяллыг аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар, Хилийн цэргийн 0245 дугаар ангитай хамтран амжилттай зохион байгууллаа.

ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

"Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Монгол цэрэг Энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааг Сэлэнгэ аймаг дахь Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагууд хамтран өнгөргөж өнгөрөгч сард өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлээ. Тодруулбал, "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг Сүхбаатар сумын "Партизаны талбай"-д зохион байгуулав. Өдөрлөгт оролцсон байгууллагууд хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, тусгай томилгоот бүлгийн хувцас хэрэглэл, Монгол Улсын болон Оросын Холбооны Улсын хилийн багана, онцгой байдлын гал унтраах багаж, зэвсэглэл техникийн үзэсгэлэнг дэлгэж, зохион байгуулсан ба тус арга хэмжээнд нийт 650 гаруй ард иргэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид өргөнөөр оролцсон. Арга хэмжээнд Хилийн цэргийн 0101 дүгээр ангиас НҮБ-ын энхийг дэмжих болон Олон Улсын бусад ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн энхийг сахиулагчдыг алдаршуулж, түүхэн замналыг нь мөнхжүүлэн ангийн хүндэтгэлийн өргөөнд "Энхийг



сахиулагчийн өрөө"-г шинээр байгуулан тохижуулсан юм.

Мөн Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим алба хаагчдыг Хилийн төлөө

медалиар шагнасан юм. Мөн Монгол Улсын Төрийн хошой шагналт Ардын жүжигчин Зууны манлай хөгжмийн зохиолч Лувсанжамбын Мөрдоржийн нэрэмжит, цэргийн гавьяаны одонт Хилийн Цэргийн дуу бүжгийн чуулгын уран бүтээлчид урлагийн тоглолтоор үйлчиллээ.

Хошууч М.ГАНБАТ

БАЙТ ХАРВААНЫ УЛААНБААТАР ХОТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД "АЛДАР"-ЫНХАН ТЭРГҮҮЛЛЭЭ



Байт харвааны Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд байрлах байт харвааны 360 төвд энэ сарын 4-5-ны хооронд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд 8 байгууллагын 70 гаруй тамирчид онч мэргэнээ сорин

өрсөлдсөнөөс, Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны ахмад Б.Ганзориг дасгалжуулагчтай баг тамирчид 2 алт, 3 мөнгө, 2 хүрэл тус тус хүртэж багийн дүнгээр тэргүүн байр эзэллээ. Үүнд, эрэгтэй ганцаарчилсан харваанд ОУХМ ахлагч

Б.Отгонболд мөнгөн медаль, спортын мастер Ө.Нэхийт хүрэл медаль, спортын дэд мастер Б.Буянтушиг 4 дүгээр байр. Эмэгтэй ганцаарчилсан харваанд спортын мастер П.Мишээлт алтан медаль, О.Халиунсайхан 4 дүгээр байр. Эрэгтэй компаунтын ганцаарчилсан харваанд спортын дэд мастер Л.Мөнхбаатар алтан медаль хүртсэн бол эрэгтэй баг ОУХМ ахлагч Б.Отгонболд, спортын мастер Ө.Нэхийт, Б.Тэнгисболд нар тус тус мөнгөн медаль. Спортын мастер М.Энхбаяр, Э.Батбилэг, спортын дэд мастер Б.Буянтушиг нар хүрэл медалийн эзэд болов. Эмэгтэй багийн харваанд спортын мастер П.Мишээлт, О.Халиунсайхан, спортын дэд мастер Э.Одонгуа нар мөнгөн медаль, холимог багийн харваанд ОУХМ ахлагч Б.Отгонболд, спортын мастер П.Мишээлт нар мөнгөн медаль тус тус хүртээ.

"АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЭ" ХАНДИВЫН АЯНД НЭГДЭВ

Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Завхан аймгийн Сонгино сумын харьяат У.Анударь охины "Амьдрал бэлэглээ" хандивын аянд тус ангийн хамт олон нэгдэж олон талын арга хэмжээнүүдэд оролцож байгаа юм. Тухайлбал, Завхан аймгийн Волейболын нэгдсэн группээс Улиастай хотод үйл ажиллагаагаа явуулдаг Төрийн болон Төрийн бус байгууллагуудын дунд зохион байгуулсан гар болон сагсан бөмбөг, өсвөр үе болон насанд хүрэгчдийн "ширээний теннис" дан болон хосын төрөл, "дартс"-ын дан болон хосын төрлүүдэд оролцов.

Тэмцээн энэ сарын 3-5-ны өдрүүдэд аймгийн "Спорт хороо"-нд зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд ангиас оролцон эрэгтэй баг тамирчид гар бөмбөгийн

төрөлд тэргүүн байр, сагсан бөмбөгийн төрөлд дэд байрт тус тус шалгарч Зэвсэгт хүчин, анги байгууллагаа сурталчилж, сайн үйлсийн аянд нэгдэж ажиллаа.



ХИЛИЙН ЦЭРГИЙН АНГИУДАД АЖИЛЛАВ

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Батлан хамгаалахын сайдын Өмнөговь аймгийн Засаг даргатай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 2.8 дахь заалтын дагуу аймгийн Засаг дарга Хилийн цэргийн 0168 дугаар ангид алба хааж буй дайчдаа эргэн, албаны үйл ажиллагаатай танилцав.

Тус ангид 2021 оны 2 дугаар ээлж, 2022 оны 1 дүгээр ээлжээр татагдсан дайчид албаа хааж байгаа бөгөөд засаг дарга тэргүүтэй бүрэлдэхүүн дайчдаа болон заставд ажиллаж амьдарч байгаа бяцхан хилчиддээ гарын бэлэг гардуулав. Мөн энэ үеэр дайчидтай хийх уулзалтыг цахимаар ар



гэрт нь хүргэсэн ба ангийн бүрэлдэхүүний бэлтгэсэн концерт, шинэ дайчдын гардан тулааны болон жагсаалын үзүүлэх тоглолт, хүчит 32 бөхийн барилдаан, морин спортын үзүүлбэр,

хилийн цэргийн анги салбар ашиглагдаж байгаа сургалтын материал хэрэгсэл, галт зэвсэг, хуурай хүнс бусад зүйлсийн үзэсгэлэн энэ үеэр дэлгэжээ.

Дэд хурандаа Д.УЛАМБАЯР